

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **БӨА-2023/158/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

---

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>16,947,610.00</u></b>	<b><u>16686860.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,947,610.00	16,686,860.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	2080650.00	0.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14866960.00	16686860.00
35410	Бичиг хэргийн материал	440000.00	250000.00
35420	Аж ахуйн материал	190000.00	110000.00
35470	Бусад хангамжийн материал	14236960.00	16326860.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,156,378,129.54</u></b>	<b><u>1,201,211,569.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,156,378,129.54	1,201,211,569.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,149,628,129.54	1,193,531,569.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,087,177,571.00	1,087,177,571.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,905,727.04)	(117,370,414.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,700,000.00	75,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(86,580,555.50)	(34,063,888.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,431,708.96	185,266,118.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,911,529.57)	(41,040,630.18)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,749,733.91	58,078,449.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,527,302.22)	(21,809,866.63)
39217	Ном	1494230.00	1494230.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6750000.00	7680000.00
39301	Програм хангамж	715000.00	715000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-715000.00	-715000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6750000.00	7680000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,173,325,739.54</u></b>	<b><u>1,217,898,429.43</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1173325739.54</u></b>	<b><u>1217898429.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,173,325,739.54	1,217,898,429.43

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	199,682,674.00	200,612,674.00
51101	Өмч: - төрийн	199,682,674.00	200,612,674.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	937,041,265.54	980,683,955.43
51210	Өмнөх үеийн үр дүн	937,041,265.54	937,041,265.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,642,689.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	36,601,800.00	36,601,800.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,173,325,739.54</u></b>	<b><u>1,217,898,429.43</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>779,641,614.00</b>	<b>821,831,650.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,189,000.00</b>	<b>79,235,950.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,189,000.00	79,235,950.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,189,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,189,000.00	79,235,950.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>775,452,614.00</b>	<b>742,595,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	775,417,614.00	724,700,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	728,921,100.00	724,700,700.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	46,496,514.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35,000.00	17,895,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,895,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>680,599,374.73</b>	<b>778,188,960.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>680,599,374.73</b>	<b>778188960.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	628114058.01	734161487.96

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	419498336.98	495175826.71
210101	Үндсэн цалин	419498336.98	421530584.64
210102	Нэмэгдэл		57056618.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		12570711.07
210104	Урамшуулал		4017913.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52154650.30	59,591,723.14
210201	Тэтгэврийн даатгал	35391050.30	40595167.46
210202	Тэтгэмжийн даатгал	4190900	4775900.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	3352700	3820725.61
210204	Ажилгүйдлийн даатгал	838200	945451.7
210205	Эрүүл мэндийн даатгал	8381800	9454478.04
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37500178.00	41425818.00
210301	Гэрэл, цахилгаан	2270375.00	2496118.00
210302	Түлш, халаалт	32726422.00	36372556.00
210303	Цэвэр, бохир ус	2503381.00	2557144.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25540410.00	31372729.00
210401	Бичиг хэрэг	9896559.00	9479788.00
210402	Тээвэр, шатахуун	9380370.00	12348490.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1784241.00	2753581.00
210404	Ном, хэвлэл	101100.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1000000.00	686000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3378140.00	6104870.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	1500000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1500000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29888230.00	7569200.00
210604	Урсгал засвар	29888230.00	7569200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2888350.00	3166000.00
210702	Дотоод албан томилолт	2888350.00	3166000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11079268.00	4115151.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,705,100.00	3,921,783.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1984300.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118868.00	122368.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210807	Газрын төлбөр	27000.00	27000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	49,564,634.73	90245040.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2605200.00	3026530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6560000.00	21645000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40399434.73	65573510.11

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52,485,316.72	44027472.15
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500000.00	2260000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500000.00	279000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1981000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	51985316.72	41767472.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51985316.72	41,767,472.15
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>99042239.27</b>	<b>43642689.89</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	34982.50	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34982.50	0.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-34982.50	0.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>99007256.77</b>	<b>43642689.89</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>728956100.00</b>	<b>742595700.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>728956100.00</b>	<b>742595700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	728921100.00	724700700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	728921100.00	724700700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35000.00	17895000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	17895000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35000.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>649115400.00</b>	<b>712354700.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>649115400.00</b>	<b>712354700.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>596630083.28</b>	<b>668327227.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	413485487.28	492838631.85
210101	Үндсэн цалин	282104716.46	319665109.00
210102	Нэмэгдэл	110624641.06	128737296.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20756129.76	24468320.00
210104	Урамшуулал		19967906.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58167500.00	61928918.00

210201	Тэтгэврийн даатгал	41403900.00	40713995.25
210202	Тэтгэмжийн даатгал	4190900.00	7114971.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	3352700.00	3831902.86
210204	Ажилгүйдлийн даатгал	838200.00	933456.84
210205	Эрүүл мэндийн даатгал	8381800.00	9334591.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37496978.00	41425818.00
210301	Гэрэл, цахилгаан	2270375.00	2496118.00
210302	Түлш, халаалт	32723222.00	36372556.00
210303	Цэвэр, бохир ус	2503381.00	2557144.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25063170.00	26558992.00
210401	Бичиг хэрэг	10149759.00	8902688.00
210402	Тээвэр, шатахуун	8280370.00	10170273.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1784241.00	2753581.00
210404	Ном, хэвлэл	101100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1000000.00	686000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3747700.00	4046450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	0.00	1500000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	1500000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35989330.00	7174200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5051100.00	35000.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	30938230.00	7139200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3080850.00	3166000.00
210702	Дотоод албан томилолт	3080850.00	3166000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11986768.00	6469368.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9612600.00	6276000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1984300.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118868.00	122368.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	44000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	27000.00	27000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11360000.00	27265300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4800000.00	5620300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6560000.00	21645000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52485316.72</b>	<b>44027472.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500000.00	2260000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500000.00	2260000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51985316.72	41767472.15
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51985316.72	41767472.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b><u>79840700.00</u></b>	<b><u>30241000.00</u></b>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>79840700.00</b>	<b>30241000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<b>79840700.00</b>	<b>30241000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	79840700.00	30241000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,840,700.00	30,241,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b><u>-79840700.00</u></b>	<b><u>-30241000.00</u></b>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-10448600.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10448600.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

##### Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	199,682,674.00	36,601,800.00	838,034,008.77	1,074,318,482.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>199,682,674.00</b>	<b>36,601,800.00</b>	<b>838,034,008.77</b>	1,074,318,482.77
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	99,007,256.77	99,007,256.77
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>199,682,674.00</b>	<b>36,601,800.00</b>	<b>937,041,265.54</b>	1,173,325,739.54
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>199,682,674.00</b>	<b>36,601,800.00</b>	<b>937,041,265.54</b>	1,173,325,739.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>199,682,674.00</b>	<b>36,601,800.00</b>	<b>937,041,265.54</b>	1,173,325,739.54
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	930,000.00	0.00	0.00	930,000.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	43,642,689.89	43,642,689.89

D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	200,612,674.00	36,601,800.00	980,683,955.43	1,217,898,429.43
-----	---------------------------------------	----------------	---------------	----------------	------------------

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>724,700,700.00</b>	<b>682,933,227.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	724,700,700.00	682,933,227.85
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	722,440,700.00	680,673,227.85
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	530,148,900.00	492,838,631.85
210101	Үндсэн цалин	295,749,800.00	319,665,109.00
210102	Нэмэгдэл	197,426,100.00	128,737,296.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,938,000.00	24,468,320.00
210104	Урамшуулал	8,035,000.00	19,967,906.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,268,700.00	61,928,918.00
210201	Тэтгэврийн даатгал	45,556,400.00	40,713,995.25
210202	Тэтгэмжийн даатгал	5,178,100.00	7,114,971.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,142,500.00	3,831,902.86
210204	Ажилгүйдлийн даатгал	1,035,600.00	933,456.84
210205	Эрүүл мэндийн даатгал	10,356,100.00	9,334,591.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,496,000.00	41,425,818.00
210301	Гэрэл, цахилгаан	2,500,700.00	2,496,118.00
210302	Түлш, халаалт	36,492,100.00	36,372,556.00
210303	Цэвэр, бохир ус	2,503,200.00	2,557,144.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,559,000.00	26,558,992.00

210401	Бичиг хэрэг	8,657,300.00	8,902,688.00
210402	Тээвэр, шатахуун	9,751,000.00	10,170,273.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,235,700.00	2,753,581.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	686,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,964,000.00	4,046,450.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,139,200.00	27,139,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	7,139,200.00	7,139,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,166,000.00	3,166,000.00
210702	Дотоод албан томилолт	3,166,000.00	3,166,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,792,600.00	11,745,368.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,552,000.00	11,552,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	169,600.00	122,368.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	27,000.00	27,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	14,370,300.00	14,370,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,620,300.00	5,620,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,750,000.00	8,750,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,260,000.00	2,260,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,260,000.00	2,260,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	2,260,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	724,700,700	682,933,227.85
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	724,700,700	682,933,227.85
131001	Улсын төсвөөс санхүүжих	724,700,700	682,933,227.85

<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>23</b>
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	11	11
620003	Үйлчлэх ажилтан	11	11
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>23</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	8	8
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	3	3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35000.00</b>	<b>17895000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>35000.00</b>	<b>17895000.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	35000.00	17895000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>35000.00</b>	<b>17895000.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	35000.00	17895000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	35000.00	17895000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	35000.00	17,895,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,895,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг бие даасан хараат бус шүүх эрх мэдлийг хөгжүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Улсын Ерөнхий прокурорын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Прокурорын байгууллагаас 2022 онд дэвшүүлэх зорилт”-ыг баталсан байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааг их өгөгдөлд суурилсан бодлогын иновацаар удирдах
- Хүний эрх,эрх чөлөө,нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх,зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээх”
- Прокурорын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй, хялбар болгох”
- Прокурор, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийгмийн хөгжлийн шинэ хандлагад нийцсэн хувь хүнийг төлөвшүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Баян-Өлгий аймгийн Прокурорын газар нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын Прокурорын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Аймгийн Прокурорын газар нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Улсын Ерөнхий Прокурорын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 тушаалаар баталсан Нягтлан бодох бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44.6 сая төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн байна.

#### *Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	16,947.6	16,686.9	260.7
Үндсэн хөрөнгө	1,156,378.1	1,201,211.6	44,833.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,173,325.7</b>	<b>1,217,898.4</b>	<b>44,572.7</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,173,325.7	1,217,898.4	44,572.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,173,325.7</b>	<b>1,217,898.4</b>	<b>44,572.7</b>

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гараагүй бол бараа материалын дансанд бага дүнтэй, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 0.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 44.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 30.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 20.0 сая төгрөг, Гэм хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 10.0 сая төгрөг, газрын хэмжээний өөрчлөлт буюу сайжруулалтаар 0.9 сая төгрөг, авто тээврийн хэрэгслийн дахин үнэлгээний нэмэгдэл 22.0 сая төгрөг, Улсын Ерөнхий прокурорын газраас 27.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 65.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 44.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 719.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 60.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.9 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 0.4 сая төгрөгөөр нэмэгдэж байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.6 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3.4 сая төгрөгөөр, нормативт зардал 1.8 сая төгрөгөөр, томилт, зочны зардал 0.4 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 46.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 0.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.5 сая төгрөгөөр бууруулж нийт 5.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 724.7 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Тайлант оны батлагдсан төсвийг 65.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 724.7 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 724.7 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 682.9 сая төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 41.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой. Жилийн эцэст улсын төсөвт 41.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	716,340.7	674,573.2	-41,767.5	94.2%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,260.0	2,260.0	0	100%
3	Байцаан шийтгэх ажиллагаа	6,100.0	6,100.0	0	100%
	<b>Дүн</b>	<b>724,700.7</b>	<b>682,933.2</b>	<b>-41,767.5</b>	<b>94.2%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Прокурорын газар нь 2022 онд Аймгийн Гэм хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн зардлаас 17.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, гүйцэтгэлээр 17.9 сая төгрөгийг зориулалтаар нь зарцуулсан зарцуулсан байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Прокурорын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Прокурорын газар нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Прокурорын газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01/106 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Прокурорын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 13.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 37.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4.3 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлуудыг 0.1 сая төгрөгөөр нийтдээ 41.7 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 41.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Хэмнэсэн шалтгаан нь төсвийн төслөөс 63.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөв баталсантай холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Тайлант онд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой нийт 12 тушаал, шийдвэр гарснаас 11 мэдээллийг хугацаанд, 1 мэдээллийг орхигдуулан мэдээлсэн байна. Мэдээлээгүй шийдвэр нь захиргаа, үйлчилгээний ажилтнуудад олгох 1.4 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр байна. Аймгийн Прокурорын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилт 97.5 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илэрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, албан шаардлага өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.



